



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 374

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоолын хавсралтад дор дурдсан агуулгатай дэд заалт нэмсүгэй:

1/ 3.2.3.2 дахь дэд заалт:

“3.2.3.2.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт;”

2/ 9.1.2.1 дэх дэд заалт:

“9.1.2.1.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт;”

3/ 12.2.4 дэх дэд заалт:

“12.2.4.Бодлогын баримт бичгийн явцын тайланг шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн явцад гарсан эерэг өөрчлөлтийн өссөн (буурсан) дүнгээр энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд цахим системд оруулаагүй.”

2. Мөн журмын 10.7.2 дахь дэд заалтын “мэдээ, тайланг” гэсний өмнө “хагас жилийн болон жилийн эцсийн” гэж, “холбогдох” гэсний өмнө “жилийн эцсийн тайланг” гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын 3.2.3.8, 7.6, 7.8, 9.9, 11.1, 12.1 дэх заалт, дэд заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 3.2.3.8 дахь дэд заалт:

“3.2.3.8.Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;”

2/ 7.6 дахь заалт:

“7.6.Үндэсний хэмжээнд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг:

7.6.1.Захиргааны байгууллага нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд;

7.6.2.Захиргааны байгууллага нь Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд;

7.6.3.Захиргааны байгууллага нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд;

7.6.4.Захиргааны байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд;

7.6.5.Захиргааны байгууллага нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд;

7.6.6.Захиргааны байгууллага нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжилтийн тайланг нэгтгэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянан үзэж дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.”

3/ 7.8 дахь заалт:

“7.8.Захиргааны байгууллага нь урт болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийг хүчингүй болсонд тооцсон, эсхүл хугацаа дуусмагц эцсийн үнэлгээ болон бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хийж, дүнг энэ журмын 8 дугаар хавсралтын дагуу гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ;”

4/ 9.9 дэх заалт:

“9.9.Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний

төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг тухайн яам гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ.”

5/ 11.1 дэх заалт:

“11.1.Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан нийт гурван яам (ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яамдаас тус бүр нэгээс доошгүй байх), нутгийн захиргааны таван байгууллагад тус бүр 100.0 сая хүртэлх төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.”

6/ 12.1 дэх заалт:

“12.1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан салбарын сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон Тамгын газрын даргад Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага ногдуулна.”

4. Мөн журмын 3.2.1 дэх дэд заалтын “6 дугаар зүйлд” гэснийг “4.1.4-4.1.14, 9.6.5” гэж, 3.2.3.2-3.2.3.10 дахь дэд заалтын дугаарлалтыг “3.2.3.3-3.2.3.11” гэж, 6.2.3.2 дахь дэд заалтын “99” гэснийг “100” гэж, 6.2.3.3 дахь дэд заалтын “31-69” гэснийг “30-70” гэж, 6.3.2 дахь дэд заалтын “89” гэснийг “90” гэж, 6.3.3 дахь дэд заалтын “49” гэснийг “50” гэж, 6.3.4 дэх дэд заалтын “9” гэснийг “10” гэж, 6.7 дахь заалтын “Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт” гэснийг “Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт” гэж, 9.1.2.1-9.1.2.6 дахь дэд заалтын дугаарлалтыг “9.1.2.2-9.1.2.7” гэж, 9.3 дахь заалтын “Засгийн газраар батлуулна” гэснийг “батална” гэж, 9.6 дахь заалтын “Хэрэглэгчийн үнэлгээг хийх” гэснийг “Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан ерөнхий удирдамжийг баримтлан” гэж, 9.8 дахь заалтын “4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор” гэснийг “3 дугаар сарын 1-ний өдрийн дотор” гэж тус тус өөрчилсүгэй.

5. Мөн журмын 10.7.2, 12.2.3 дахь дэд заалтын “Засаг даргын зөвлөл,” гэснийг тус тус хассугай.


6. Мөн журмын 1, 5, 7, 9 дүгээр хавсралтыг 1 дүгээр хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

7. Мөн журмын 3 дугаар хавсралтыг 3а, 3б, 3в хавсралт болгон 2 дугаар хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

8. “Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийг тайлагнах загвар”-ыг мөн журмын 10а,10б хавсралт болгон 3 дугаар хавсралт ёсоор баталсугай.

9. “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг мөн журмын 11 дүгээр хавсралт болгон 4 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

10. Энэ тогтоолыг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.




Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Ц.НЯМДОРЖ



Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 1 дүгээр хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

Тайлангийн төрөл	Тайлангийн нэр	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага	Тайлан хүргүүлэх хугацаа	Тайлан хүлээн авах байгууллага	Давтамж	Тайлагнах байгууллага, хугацаа
1	2	3	4	5	6	7
Бодлогын баримт бичиг	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	10.01-ний өдрийн дотор	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Явц-2 жил тутам, (Тэгш онд)	Засгийн газарт 11 дүгээр сард танилцуулна.
		Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	09.01-ний өдрийн дотор	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	(ХШҮ-хуульд заасан хугацаанд)	
	Хөгжлийн зорилтот хөтөлбөр	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	09.01-ний өдрийн дотор	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Явц-жил тутам, (ХШҮ-хуульд заасан хугацаанд)	Засгийн газарт 10 дугаар сард танилцуулна.
		Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	08.01-ний өдрийн дотор	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		
	Монгол Улсыг	Үндэсний	01.15-ны	Засгийн газрын	Явц-жил	Засгийн

хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	өдрийн дотор	Хэрэг эрхлэх газар	тугам, (ХШУ-хуульд заасан хугацаанд)	газарт 1 дүгээр сард танилцуулна. УИХТГ, УАГ-т 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ.
	Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	01.01-ний өдрийн дотор	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт)	Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	01.01-ний өдрийн дотор, 07.01-ний өдрийн дотор цахим системээр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хагас жил тутам, Сар бүр цахим системээр тайлагнана	Засгийн газарт 1 дүгээр сард, 9 дүгээр сард танилцуулна УИХТГ, УАГ-т 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ. УИХ-д хуулийн хугацаанд өргөн мэдүүлнэ.
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	01.15-ны өдрийн дотор, 07.01-ний өдрийн дотор цахим системээр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хагас жил тутам, Сар бүр цахим системээр тайлагнана	Засгийн газарт 1 дүгээр сард, 9 дүгээр сард танилцуулна. УИХТГ, УАГ-т 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ.
	Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	01.01-ний өдрийн дотор, 06.15-ны өдрийн дотор цахим системээр	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		УИХ-д хуулийн хугацаанд өргөн мэдүүлнэ.

	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	03.15-ны өдрийн дотор	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Жил тутам	Засгийн газарт 4 дүгээр сард танилцуулна.
		Аймаг, нийслэл, хот	03.01-ний өдрийн дотор	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		
	Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хамт)	Аймаг, нийслэл	02.01-ний өдрийн дотор	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Жил тутам	Засгийн газарт 4 дүгээр сард танилцуулна.
	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө	Аймаг, нийслэл, хот	02.01-ний өдрийн дотор	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Жил тутам	Засгийн газарт 4 дүгээр сард танилцуулна.
	Хуульд нийцүүлэн хүчингүй болсон тооцсон болон хугацаа дууссан бодлогын баримт бичгийн тайлан	Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	Хүчингүй болсон, хугацаа дууссан өдрөөс хойш 6 сарын дотор	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хагас жилд 1 удаа	ЗГХЭГ хагас жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг,	Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг,	02.15-ны өдрийн дотор, 07.10-ны	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Хагас жил тутам, Сар бүр цахим	Засгийн газарт 3 дугаар сар, 9 дүгээр сард танилцуулна.

	ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт	нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	өдрийн дотор		системээр тайлагнана	УИХ, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ҮАБЗ-ийн Ажлын албанд 4 дүгээр сар, 9 дүгээр сард хүргүүлнэ.
Төсөл	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	03.15-ны өдрийн дотор	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Жил тутам	Засгийн газарт 4 дүгээр сард танилцуулна.
		Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	03.01-ний өдрийн дотор	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага		
Байгууллагын үйл ажиллагаа	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт	Захиргааны байгууллага (Яам, агентлаг, аймаг, нийслэл) эрхлэх асуудлын хүрээнд	02.01-ний өдрийн дотор	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	ХШҮ- 2 жил тутам	ЗГХЭГ хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт		03.01-ний өдрийн дотор		Жил тутам	Засгийн газарт 4 дүгээр сард танилцуулна.
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт					
	Байгууллагын ил тод байдлын үнэлгээ					
Тухайн жилийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан						

Товчилсон үгийн жагсаалт:

-УИХ -Улсын Их Хурал
 -ҮАБЗ -Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
 -УИХТГ -Улсын Их Хурлын Тамгын газар

-ЗГХЭГ - Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
 -ҮАГ- Үндэсний аудитын газар
 -ХШҮ - Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 5 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Монгол Улсын хууль					
Хэсгийн дундаж: хувь					
Улсын Их Хурлын тогтоол					
Хэсгийн дундаж: хувь					
Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол					
Хэсгийн дундаж: хувь					
Ерөнхийлөгчийн зарлиг					
Хэсгийн дундаж: хувь					
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл					
Хэсгийн дундаж: хувь					
Засгийн газрын тогтоол					
Хэсгийн дундаж: хувь					
Ерөнхий сайдын захирамж					
Хэсгийн дундаж: хувь					
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
Хэсгийн дундаж: хувь					
Засгийн газрын албан даалгавар					
Хэсгийн дундаж: хувь					
Нийт дундаж: хувь					

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 7 дугаар хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
(... он)

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт		0.5	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт			
	3. Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт			
	4. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт			
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт			
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт		0.15	
	2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт			
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт			
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдал		0.2	
	2. Шилэн дансны хөтлөлт			
	3. Шударга байдлын түвшин			
	4. Хэрэглэгчийн үнэлгээ			
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт		0.15	
Ерөнхий үнэлгээ:			1.0	


Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9 дүгээр хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;		
1.2.	чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;		
1.3.	эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;		
1.4.	хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;		
1.5.	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;		
1.6.	үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;		
1.7.	албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;		
1.8.	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;		
1.9.	хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;		
1.10.	мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.		
Хэсгийн дундаж хувь:			
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;		
2.2.	албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;		
2.3.	албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;		
2.4.	хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;		
2.5.	хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;		
2.6.	албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.		
Хэсгийн дундаж хувь:			
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
3.1.	өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;		
3.2.	төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;		

3.3.	санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;		
3.4.	хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;		
3.5.	төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;		
3.6.	таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;		
3.7.	цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;		
3.8.	бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;		
3.9.	шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;		
3.10.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан		
3.11.	худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;		
3.12.	мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;		
3.13.	төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;		
3.14.	мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;		
3.15.	хууль тогтоомжид заасан бусад.		
Хэсгийн дундаж хувь:			
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
4.1.	үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;		
4.2.	тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.		
Хэсгийн дундаж хувь:			
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;		
5.2.	эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;		
5.3.	хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;		
5.4.	мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;		
5.5.	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь		

	хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;		
5.6.	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;		
5.7.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;		
5.8.	мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;		
5.9.	барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;		
5.10.	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;		
5.11.	нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;		
5.12.	мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;		
5.13.	хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.		
Хэсгийн дундаж хувь:			
Хэрэгжилтийн дундаж хувь:			



Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 3а хавсралт

УРТ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ЗАГВАР

Бүлгийн нэр:

Зорилго:

Зорилт:

Үйл ажиллагаа:

Санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ: (Хөгжлийн зорилтот хөтөлбөрт хамаарна)

Хэрэгжилт/үр дүн:

---o0o---

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 3б хавсралт

... ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (..... ОН)

Дугаар	ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ**	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Бүлгийн нэр:												


* Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг

** Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хувьд төсөл, арга хэмжээ гэж ойлгоно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 3в хавсралт

... ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (..... ОН)

Дугаар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Бүлгийн нэр							



Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 10а хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 20... ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ


Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ оны төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин
НЭГ. "....." ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫН ХҮРЭЭНД					
1.1.	Арга хэмжээ				
1.2.	Арга хэмжээ				


Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 10б хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 20... ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ЗАГВАР

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар /
НЭГ. "....." ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫН ХҮРЭЭНД					
1.1.	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ. Хэрэгжилтийн хувь
1.2.	Арга хэмжээ				Хүрсэн түвшин буюу арга хэмжээний хэрэгжилтийг бичнэ. Хэрэгжилтийн хувь

---o0o---





Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 11 хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (202... он)	Хүрэх түвшин (202... он)	Тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага	Мэдээлэл цуглуулах арга зүй	Хүрсэн түвшин (202... он)
Нэг.Ногоон байгууламж (Мод тарих)								
1	2	3	4	5	6	7	8	9
Шинээр тарьсан мод	Ширхэг			Үрээр болон тарьц, суулгацаар шинээр тарьж ургуулсан мод, сөөгний тоо	Жилд нэг удаа	Аймаг, Нийслэлийн ЗДТГ, БОАЖЯ	Тайлан	-
Ургалтын хувь	Хувь			Тухайн жилд шинээр тарьсан модонд 75 хувиас дээш ургалттай модны эзлэх хувь	Жилд нэг удаа	Аймаг, Нийслэлийн ЗДТГ, БОАЖЯ	Тайлан	-
Хот суурины эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь	Хувь			Тухайн хот суурингийн эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь	Жилд нэг удаа	Аймаг, Нийслэлийн ЗДТГ, БОАЖЯ	Статистик мэдээ	-
Хоёр.Цахим шилжилт								
Орон нутгийн цахим үйлчилгээний индекс	индекс			НҮБ-ын цахим засаглалын хөгжлийн индекс тодорхойлдог аргачлал болон "E-Mongolia" цахим үйлчилгээний систем	Жилд нэг удаа	ЦХХХЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ	Судалгаа, "E-Mongolia" цахим системийн тайлан	-
Иргэдийн цахим оролцооны индекс	индекс			Шийдвэр гаргалт, хөрөнгө оруулалтад санал болон өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр авч буй байдал	Жилд нэг удаа	ЦХХХЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ	Судалгаа, 1111 төвийн мэдээллийн системийн тайлан	-

Дотоод үйл ажиллагааны удирдлагын систем нэвтрүүлэлт	Хувь			Дотоод удирдлагын систем ашиглаж буй орон нутгийн төрийн байгууллагуудын тоо	Жилд нэг удаа	ЦХХХЯ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ	Тайлан	-
"E-Mongolia" цахим үйлчилгээний хамрагдалт	Хувь			"E-Mongolia" цахим үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог тухайн орон нутгийн насанд хүрсэн иргэдийн тоонд харьцуулан хувиар илэрхийлнэ.	Жилд нэг удаа	ЦХХХЯ	Судалгаа, тайлан	-
Гурав.Хог хаягдлын менежмент								
Хог хаягдлын эдийн засгийн эргэлт	Хувь			Тухайн жилд боловсруулсан хог хаягдлыг нийт хог хаягдлын хэмжээнд харьцуулж, хувиар илэрхийлнэ.	Жилд нэг удаа	Аймаг, Нийслэлийн ЗДТГ, БОАЖЯ	Статистик мэдээ	-
Ил задгай хог хаягдалгүй байх	Оноо			Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгээр	Жилд нэг удаа	ЗГХЭГ, Судалгааны байгууллага	Түүвэр судалгаа, асуумж	-

---o0o---

